Орон бүхний пролетари нар нэгдэгтүн

# Анхдугаар ТАВАН ЖИЛ

Төв аймгийн намын хороо, А.Д.Х. Гүйцэтгэх захиргааны сонин.

21 дэхь жилдээ | № 39 (1728) | 1968 ОНЫ 5 ДУГААР САРЫН 27 | ДАВАА

## Аймгийн намын бага хурал

Тус аймгийн намын байгууллагуудын дээд эрхийг барих намын ээлжит XIV бага хурал энэ оны 6 дугаар сарын эцсээр болно.

Бага хурал нь аймгийн намын байгууллагуудаас өнгөрсөн 2 жилийн дотор аймаг орны аж ахуй, соёлын төлөвлөгөөг биелүүлэхийн тулд зохиож ирсэн намын зохион байгуулалт үзэл суртлын ажлыг нэгтгэн дүгнэж түүнийг цаашид улам боловсронгуй болгох, аж ахуйг удирдах намын удирдлагыг улам сайжруулахад чиглэгдэнэ.

Тус аймгийн бүтээлч хөдөлмөрчид 1968 оны аж ахуй, соёлын төлөвлөгөөг биелүүлэх тэмцэлдээ багагүй амжилтуудыг гаргаж байна.

Энэ оны 1 дүгээр улирлын социалист уралдааны дүнгээс үзэхэд Дэлгэрхаан, Баянзүрх сумд тэргүүн байруудыг эзэлсний дотор Баян, Дэлгэрхаан сумд малын төл бойжуулах төлөвлөгөөг биелүүлж яваагийн гадна Мөнгөнморьт, Баяндэлгэр сумд малын элдэв хорогдлыг өнгөрсөн жилийн энэ үеийнхээс эрс багасгаж чадсан байна.

Гэвч байгаа нөөц бололцоогоо дүүрэн ашиглаж аж ахуйг хөтлөн удирдах арга барилаа шинэ нөхцөлд улам боловсронгуй болгож ажиллах талаар намын байгууллага бүр бас л жигдгүй ажиллаж байна.

Тийм газарт нам, улс, хөдөлмөрийн сахилга бат суларч ажлын хариуцлага доройтож улсын төлөвлөгөө тасалдаж байна.

Ийм илрэл үзэгдэлтэй намын гишүүд хэзээч хаана ч эвлэрч болохгүй.

Манай намын ялагдашгүй хүч чадал бол түүний олон мянган гишүүдийн нягтрал нэгдэлд бат оршдог зарчмын үндсэн дээр ажилд шүүмжлэл, өөрийн шүүмжлэлийг бүтээлчээр өрнүүлж дутагдал доголдлыг цаг тухай бүрт илрүүлэн засч байх ёстой.

Аймгийн намын бага хурлыг угтаж аймаг орны аж ахуй, соёлын эхний хагас жилийн төлөвлөгөөг хугацаанаас нь 5 хоногийн өмнө биелүүлсэн байхын тул аймгийн хэмжээгээр 5 дугаар сарын 25-наас эхлэн 1 сарын зохицтой ажлыг зохион явуулж байна.

Энэ хугацаанд малын оторлолтыг сайн зохион байгуулж, өвөлжилтийн бэлтгэл юуны өмнө хашаа барих, худаг гаргах, хуучныг сэлбэх, засах, хадлан авалт, тариа хураалтын бэлтгэлийг сайн хийж тариа ногоо, малын тэжээл тариалалт, уринш хагалалтыг дуусгасан байх ба сүү, ноос бэлтгэлийн эхний хагас жилийн төлөвлөгөөг заавал гүйцэтгэсэн байх хэрэгтэй.

Энэ зорилтыг нэр төртэй биелүүлэхийн тул албан үйлдвэр, аж ахуйн газрууд ба сумд тэдгээрийн дэргэдэх нам, эвлэл, үйлдвэрчин, эмэгтэйчүүд зэрэг олон нийтийн байгууллагууд өөрсдийн шугамаар хийж гүйцэтгэх ажлыг тодорхой төлөвлөгөө зохиож түүнийгээ биелүүлэхэд гишүүд, идэвхтэн нийт хөдөлмөрчдийн идэвхи санаачлагыг өрнүүлэх хэрэгтэй.

Үүний тул хүнтэй ажиллах ажлаа сайжруулан, зохиож байгаа ажилдаа хяналт шалгалт гүйцэтгэлийн шалгалтыг гүн гүнзгий бөгөөд бүтээлчээр нэвтрүүлэн социалист уралдааныг зохистой хэлбэрүүдээр өрнүүлэн цаг тухайд нь дүгнэж түүний явцад гарсан шинэ санаа, дэвшилттэй арга, тэргүүн туршлагыг нийтэд эзэмшүүлэх ажлыг удирдлагын аргадаа нэвтрүүлэн ажилд зарчимч шаардлагыг өндөржүүлэн ажлын хариуцлага сахилга батыг эрс дээшлүүлэх ёстой.

Бага хурал хуралдах хүртэл хугацаанд намын нийт байгууллагуудаар аймгийн Намын Хорооны ажлын тайланг авч хэлэлцүүлэх бөгөөд үүнд намын нийт байгууллагууд түүний гишүүд одоогоос сайн бэлтгэх хэрэгтэй.

Мөн энэ хугацаанд аймгийн намын V бүгд хурал болж намын байгууллагуудаас боловсон хүчинтэй ажиллах ажлыг сайжруулах ба мал аж ахуйн нөөц бололцоог ашиглах асуудал авч хэлэлцэх тул түүнээс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн биелүүлэх ажлыг аймаг орон даяар бага хурлыг угтсан бэлтгэл ажилтай хослон зохиох болно.

Энэ их ажлыг удирдан зохион байгуулахад хүчийг зөв хуваарилан хүн бүрийн үүрэг хариуцлагыг тодорхой болгож ажилдаа нарийн график төлөвлөгөөтэйгөөр ажиллах хэрэгтэй.

Манай аймгийн намын байгууллага түүний гишүүдээс аймгийн хаа намын XIV бага хурлыг намын зохион байгуулалт, үзэл суртлын ажилд улам шинэ шинэ арга туршлага нэвтрүүлсэн их амжилтаар угтаж МАХН—ын Төв Хорооны IV бүгд хурал, МАХН-ын Төв Хороо, БНМАУ—ын Сайд нарын Зөвлөлөөс зудтай тэмцэж хор уршгийг арилгах талаар гаргасан тогтоолыг хэрэгжүүлэн биелүүлэхэд их амжилт олох нь дамжиггүй юм.

Эрүүл энхийн 5 сарын аянд

## Хөдөлмөрчдийн эрүүл ахуй

Манай нам, засаг байгуулагдсан үеэсээ эхлэн ЗХУ—ын туслламжинд түшиглэн хүн ардынхаа эрүүл мэндийг хамгаалж өсөлт төрөлтийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарал тавьж ирсэн юм.

Манай орон эрүүлийг хамгаалах ажлыг хөгжүүлэх үндэс нь тус орны засгийн газраас авах арга хэмжээнд тулгуурлах бөгөөд эрүүлийг хамгаалах ажлыг тухайн улсын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөний салшгүй хэсэг болгон шийдвэрлэж чадсан орон л энэ талаар амжилт олдогийг дэлхий дахинд харууллаа.

Манай улс эрүүлийг хамгаалахын үндсэн үзүүлэлт болох ариун цэвэр, урьдчилан сэргийлэх байгууллага эмнэлгийн боловсон хүчний өсөлт, хүн амын төрөлт, цэвэр өсөлт, нэг хүнд ноогдох орны тоогоор үлэмжхэн хөгжиж чадлаа.

Ялангуяа социалист байгуулалтын чухал хэсэг болох соёлын хувьсгалын бүрэн ялалтыг хангах их ажлыг бүх талаар нь өрнүүлж байгаа одоо үед ард түмний ариун цэвэр эрүүл ахуйн соёлжилтыг хөгжүүлэх явдалд нам, улс, олон нийт үйлдвэр, аж ахуй, соёл үйлчилгээний байгууллага нийт хөдөлмөрчид чухал үүрэг гүйцэтгэж байна.

Манай аймагт хөдөлмөрчдийн эрүүл ахуй, ариун цэврийн соёлыг сайжруулах талаар аймгийн АЦХСС, Заамар, Баяндэлгэр, Дэлгэрхаан, Жаргалантын САА—н эмнэлгийн салбарууд зэрэг тэргүүний ажиллагаатай эмнэлэг, байгууллага олширлоо.

Ардын Их Хурлын 5 дахь удаагийн IV чуулганы шийдвэрийг биелүүлэх талаар санаа тавихгүй хүн амыг эрүүлжүүлэх төлөвлөгөөг чуулганаараа батлахгүй, түүнийг ажил болгох талаар санаа зовдоггүй сум—нэгдэл байсаар байна.

Баян, Баянцагаан сумд, Гачууртын САА—д одоо болтол халуун ус байхгүй юм. Бүрэн, Өнжүүл сумд халуун усны барилгатай боловч ажиллуулахгүй олон сараар хаалттай байлгадаг болжээ.

Орон нутагт ажиллаж байгаа орон тооны бус ариун цэврийн байцаагчид, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хөдөлмөрчид, албан байгууллагуудад сул тавьж байна.

Хөдөлмөрчдийн эрүүл ахуйг сайжруулахын тулд нам, улс, олон нийт, эмнэлэг урьдчилан сэргийлэх болон үйлдвэр ХАА-н байгууллагууд нийт хөдөлмөрчид төв суурин газруудад газрын хөрсийг бохирдлоос хамгаалах, ариун цэврийн байдлыг сайжруулах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар гаргасан хууль дүрэм, тогтоол шийдвэрийг биелүүлэх хэрэгтэй.

Халдварт өвчинтэй тэмцэхэд эмнэлгийн байгууллагууд хөл хорилтын журмыг сахиулах урьдчилан сэргийлэх тарилгад бүх хүмүүсийг оруулах, хортон устгах ажлыг зохион байгуулалттай явуулах, хүн амыг ундааны цэвэр усаар хүрэлцээтэй хангахын тулд худаг задгай усанд ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоож худгийг таглаатай болгох, ус түгээх тээвэрлэх сав хэрэглэлийн ариун цэврийн шаардлагыг өндөржүүлэх нь чухал юм.

Үйлдвэр, үйлчилгээ, худалдаа, тээвэр, соёл гэгээрэл, эрүүлийг хамгаалах байгууллагуудын үйлчилгээг ариун цэвэрч соёлч боловсон болгох ёстой.

Хүмүүсийн хувийн ба байр орон сууцны ариун цэвэрт байнга анхаарч төв суурин газарт тарималь зүлэг, мод, хайрган замын бүс байгуулах хэрэгтэй юм.

Ялангуяа малчдын эрүүл ахуйн төлөө онцгой анхаарал тавьж бригадын төв суурьудыг нэгдсэн халуун устай болгох, хашаа барих, хадлан хадах, худаг ухах, ноос, хөөврийн үед ариун цэврийн шаардлагыг өвөрмөц хэлбэрээр тавих, ариун цэврийн бараа ариутгалын материалаар хангах, хөдөлмөрийн цаг, амралт, хооллолтыг зохицуулах хэрэгтэй.

Ариун цэвэр, эрүүл ахуйн сурталчилгаа нэвтрүүлгийг олон хэлбэрээр нийтийг хамран зохиох явдал хөдөлмөрчдийн эрүүл ахуйг сайжруулахад шийдвэрлэх нөлөөтэй гэдгийг онц анхаарах хэрэгтэй.

Хөдөлмөрчдийн эрүүл ахуйд үйлдвэр аж ахуй, соёл шинжлэх ухааны байгууллага, ардын үйлдвэрлэлийн нэгдлүүдээс сүүлийн жилүүдэд өрнүүлж байгаа шинэ арга ажиллагаа баялаг туршлагыг дэлгэрүүлж, иргэн бүрийн эрүүл мэндээ хамгаалах ухамсар мэдлэгийг улам дээшлүүлж нам, улс, олон нийтийн байгууллагын идэвхтэй туслалцаанд тулгуурлан эрүүл энхийн үзлэгийг хөдөлмөрийн амжилттай нягт холбох хэрэгтэй байна.

Б.Цэдэн-Иш

## Бүртгэл тооцооны ажилтны идэвхийлэл

Баянцогтын САА—н бүртгэл тооцооны ажилтан нар өмнөө тавигдсан зорилтоо ухамсарлаж бүртгэл тооцооны ажлыг сайжруулахад хүч бололцоогоо дайчлан ажиллаж байна.

Тус САА—н мал аж ахуйн фермийн тоо бүртгэгч Чулуунгончиг, Очир нар суурийн тооцоог хөтлөгдөх маягтаар нь тогтмол бүрэн хөтлөж сар бүр малаа тоолж тооцоог тухай бүр боддог журамтай болов.

Хариуцсан тарианы бригадын хаа ажилд бүртгэл тооцоог бүрэн нэвтрүүлж байгаа тоо бүртгэгч Жамъянсүрэн, Энхтайван, Дашдорж, бүртгэлийн ажлыг сайжруулах талаар идэвхитэй ажиллаж байгаа мал фермийн ня-бо Намжил нарын зэрэг тэргүүний тоо бүртгэгч, ня-бо олон байна.

Энэ нөхөд зөвхөн бүртгэл тооцоог хөтлөөд зогсох бус хүмүүсийн ажлын чанарт тавих шаардлагыг өндөржүүлж байгаагаас ажлын явц сайжирч, үр дүн нь тодорхой болж байна.

Ж. Самданхүү

# Сурвалжлагын тухай

Манай сонины түшиг болсон идэвхтэн бичигчдийн тоо өдрөөс өдөрт олширч, тэд чадал хүчээ шавхан олон сайхан үнэт материал ирүүлсээр байна.

Эдний ихэнх нь идэвхтэн бичигчид байгаа бөгөөд нилээд нь зөвлөлгөө хүсэж байна.

Сонинд нийтлэж байгаа зүйлийн нэр төрөл нийтлэл, уран нийтлэл, найруулал, сурвалжлага, сурвалжилсан тэмдэглэл, тайлан мэдээ, мэдээ зэрэг олон төрөл байдаг бөгөөд тус тусдаа онцлогтой, нарийн нягт ажиллагаа шаардагдах өвөрмөц байдаг юм.

Энэ удаагийнхаа зөвлөлгөөгөөр сонины бичлэгт хамгийн өргөн дэлгэр тусгагдаж байдаг сурвалжлагын тухай товч зөвлөе.

Сурвалжлагыг бичихдээ санаанаасаа зохион бичих биш харин болсон явдлыг уран тод харуулан бичих бөгөөд тэр үйл явдал нь тодорхой газар, тодорхой цаг хугацаатай холбогдож түүнд дүрслэгдэн байгаа зүйл нь жинхэнэ үнэн бодитой хүмүүс байх юм.

Сурвалжлагад үнэн байдлыг ямар нэгэн талаар гуйвуулах явдал байж болохгүй.

Сурвалжлагын хамгийн чухал нь хөдөлмөрч хүний тухай харуулсан байх явдал билээ.

Хэрэв шинэ техникийн тухай сурвалжлага бичвэл тэр техникийг зохион бүтээсэн, үйлдвэрлэсэн хүмүүсийн тухай,тэдний хийж байгаа ажлын тухай өгүүлэх хэрэгтэй.

Түүнээс гадна сурвалжлагад, бичигчийн харьцаа байдал, сэтгэгдэл заавал тусгагдаж, ингэснээрээ болсон явдлыг уншигчдад өөрсдөө үзэж санаж байгаа юм шиг сэтгэгдэл төрүүлэх болно.

Гэхдээ сурвалжлагч зөвхөн хаана юу болсныг тоочих явдал хангалтгүй.

Сурвалжлагч болж байгаа зүйлд улс төрийн хичнээн зөв дүгнэлт хийж чадвал түүний бичсэн зүйл төдий чинээ зохион байгуулагч ухуулагч үүргээ гүйцэтгэж чадахын хамт баримтад зүйлээр үнэмшүүлэн тэднийг болсон явдалд аяндаа нэгдсэн зөв дүгнэлт хийх боломцоо олгохоор бичих хэрэгтэй. Сурвалжлага бол бодит байдлын нэг хэсэг байдаг учраас тэр хэсэг нь бодит байдлын бусад хэсэгтэй заавал зөв харилцаатай байх учиртай.

Сурвалжлагч баримт сэлтийг бөөгнөрүүлэн өөрийнхөө сурвалжлагаар чухам юуг харуулахаа бодож үүндээ тохирсон түгээмэл дүр болон баримт сонгон авбал таарна.

Гэхдээ бичигч аль хэрэгтэйгээ сонгон авч хэрэггүйг ялган орхих учиртай.

Хүмүүст өнгөрсөн, ирээдүй, одоо үеийн шинж чанар хүсэл эрмэлзэл байх учир сурвалжлагч өөрийнхөө үзэл санааг түүнд хандуулах хэрэгтэй.

Сурвалжлагад, бодит байдал зөв тодорхой дүрээр бичигдсэн байх бөгөөд тэр нь ямар нэг тайлбарлалт буюу дэлгэрэнгүй мэдээ шиг байж болохгүй.

Сурвалжлага бичигч бичлэгийн уран сайхан хэллэг, найруулга, цэцэн зүйрлэл, оновчтой жишээлэл сайн эзэмшсэн байвал бичлэг маань амжилттай болно.

Сурвалжлага нь бичлэгийн нэг төрөл бөгөөд тэр нь заавал уншигч олондоо, шинэ юм дамжуулдаг. Сурвалжлага бол хүний сэтгэл санаанд бодит зүйлийг дүрээр харуулан чаддагаараа мэдээнээс ялгаатай билээ.

Сурвалжлага нь хэмжээгээр урт богино, сэдэв нь олон янз байж болдог. Сурвалжлагыг үндсэн байдлаар нь гурван хэсэгт хувааж болно. Үүнд:

Хөргийн сурвалжлага. Энэ нь гол төлөв нэг буюу хэдэн хүнийг харуулна.

Бичигч хүн сурвалжлагад орж байгаа хүний онцлог төрх төлөв ажил үйлийг тодорхой харуулна.

Мэдээлэх сурвалжлага.Энд үндсэндээ баяр ёслол жагсаал болон гадаадаас ирж байгаа зочдыг хүлээн авах, ямар нэг үзэсгэлэн нээх гэх мэтийн мэдээлэх чанартай зүйлүүд багтах бөгөөд ийм сурвалжлагад хүмүүс гол төлөв нэр хаяг дүр зураггүй байдаг.

Гэхдээ тэр сурвалжлагад ямар баатар байгаагий нь уншигчдыг олж харахад саад болдоггүй.

Үйлдвэрлэлийн сурвалжлага.Энд юуны өмнө онцгой баатар, үйлдвэрлэл, завод, нэгдэл, САА, сургууль зэрэг орно.

Энэ бүхнийг дүгнэж хэлэхэд сурвалжлагын нэг онцлог нь болсон явдлыг зөвхөн тоочин мэдээлэх биш чухам хаана юу болсныг яруу тод харуулдаг явдал юм.

Гэхдээ сурвалжлагч болсон явдлыг яг хуулбарлан бичих хэрэг биш болсон явдлыг бодит байдалтай хамтатган бичиж дүгнэлт өгөх ёстой

Сурвалжлагын өөр нэг онцлог бол зохион бичигч өнгөрсөн буюу болж байгаа үйл явдлыг дамжуулан яригчийн үүрэг гүйцэтгэж, түүний нэрийн өмнөөс уг зүйл өгүүлэгдэнэ.

Үүнээс гадна бичигч өөрийгөө заавал гаргах явдалгүйгээр бичиж болох бөгөөд сурвалжлага нь заавал шинэ зүйлийг мэдээлэх, болсон зүйлийн олон баримтаас уншигч мэдвэл зохих хамгийн чухлыг нь шуурхай мэдээлэхэд чиглэгдэнэ. Сурвалжлага—ухуулах материал, тэр нь сонины мэдээний буюу хэллэгийн адил баримтаар ухуулдаг учраас тэр зүйлийг улс төрийн талаар хурц тод үнэлж бодиттойгоор харуулах ёстой.

Энэ бичигдсэн зүйл нь сурвалжлагыг заавал ингэж бичиж бай гэсэн жор биш харин үндсэн чиглэл нь иймэрхүү байна гэж зөвлөсөн хэрэг.

**Ц. Чулуун**

# Бүтээлч ажил

Чухал үйл явдал, бодит баримтанд тулгуурлан олон түмнийг үзэл суртлын талаар хүмүүжүүлдэг ихэвхтэн бичигч хүний үйл ажиллагаа нь бүхэлдээ ур чадвар шаарддаг бүтээлч ажил билээ.

Идэвхтэн бичигч бүхэн сонин хэвлэлд ирүүлж буй мэдээ материалаа уншигч олонд үр нөлөөтэй амьд сонирхолтой болгохын тулд бүхий л хүч авъяасаа дайчлан уйгагүй ажиллах ёстой.

Бичигч идэвхтэн юуны өмнө амьдралд болж байгаа улс, нийгмийн ач холбогдолтой, олон түмний анхаарал сонирхол татаж байгаа үйл явдлыг тухай бүр мэдээлэх хэрэгтэй.

Бичиж байгаа зүйлээ олон түмэнд гүн бат ойлгуулахын учир уг үйл явдлын талаар маш үнэн зөв дүн шинжилгээ хийх, тэрхүү бичиж байгаа зүйлээ олны анхаарлыг ихэд татаж ажил үйлсэд нь үр ашиг өгч сэтгэл санааг нь догдлуулан хөдөлгөж оюун ухаанд нь үлдэж хоцрохуйц чадварлаг бичихийг эрмэлзэх ёстой.

Идэвхтэн бичигч бүхэн бичиж байгаа зүйлээ маш нарийн чанд судлаж, баримтынхаа дотор агуулагдаж байгаа утга санааг илэрүүлэн гаргахын хамт эх хэлнийхээ арвин баялаг санг дүүрэн чөлөөтэй ашиглаж бичлэгийн онцлогт тохируулж бичиж байгаа зүйлийнхээ зохиомжийг оновчтой хийх хэрэгтэй.

Бичигч идэвхтэний бас нэг эрхэмлэн хичээх зүйл бол уг бичиж байгаа зүйлийнхээ дотор маш сонин сайхан үр ашигтай, нэвтрүүлж болохуйц чухал хэрэгтэй санаа дэвшүүлж тавих явдал мөн.

Энэ бол идэвхтэн бичигчийн үйл ажлын бүтээлч ажил даруй мөн болно.

**Б. Очирбат**

# Улсын нийгмийн даатгалын үйлчилгээнд олон нийтийн хяналтыг сайжруулъя

Тус улсын иргэн бүхэн даатгалтай байдаг бөгөөд улс, үйлдвэр, хоршоолол, олон нийтийн бүх байгууллагад ажиллахдаа улсын нийгмийн даатгалд хамрагдан үйлчлүүлдэг юм.

Нийгмийн даатгалаар ажилчин албан хаагчдад үйлчлэх ажлыг хөнгөн шуурхай болгох, түүнд тавих олон нийтийн хяналтыг сайжруулах зорилгоор аймгийн үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд өөрийн бүхий л үйл ажиллагаагаа чиглүүлж зохион байгуулалтын нилээд арга хэмжээнүүдийг жил бүр авсаар байна.

Юуны урьд нийгмийн даатгалын ажилд идэвхтнүүдийн оролцоог сайжруулахын тулд эмч, инженер, техникийн мэргэжлийн ажилтан, санхүүгийн тэргүүний ажилтны оролцоотойгоор аймгийн ҮЭ—ийн Зөвлөлийн дэргэд санхүү, нийгмийн даатгалын ажилд туслах шалгах групп, итгэмжлэгдсэн эмч, идэвхтэн эмч нарын групп, ҮЭ—ийн Хороо, бүлгүүдэд нийгмийн даатгалын зөвлөл, төлөөлөгч зэрэг идэвхтэн байгууллагууд ажиллуулах боллоо.

Аймгийн хэмжээгээр ҮЭ—ийн сонгуульт ажлаа үлгэр жишээч биелүүлдэг нийгмийн даатгалын идэвхтэн байгууллага, идэвхтний тоо жилээс жилд улам олширч байна.

Их хайрханы уулын үйлдвэр, Архуст САА, Баянчандманий дундын үйлдвэрийн дэргэдэх ҮЭ-ийн Хорооны нийгмийн даатгалын зөвлөл зэрэг нилээд зөвлөлийн дотоод ажил тогтмолжин сайжирч байна.

Их хайрханы уулын үйлдвэрийн дэргэдэх ҮЭ—ийн Хороо мэргэжилтэн эмч нарыг урьж хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуйн сэдвээр яриа хийлгэх, ажилчдыг эрүүлжүүлэх төлөвлөгөөг захиргаатай хамтран жил бүр зохиож, биелэлтийг хурлаараа хэлэлцдэг, ажилчин албан хаагчдын эрүүл мэндийн үзлэгийг тогтмол явуулдаг болжээ.

Улсын нийгмийн даатгалын үйлчилгээг сайжруулах нөгөө нэг гол нөхцөл бол нийгмийн даатгалын хөрөнгийн төлөлт, зарцуулалтад байнга хяналт тавих явдал мөн.

Аймгийн ҮЭ—ийн Зөвлөл зөвхөн 1967—68 онд нийгмийн даатгал бүхий 83 газарт нийгмийн даатгалын хөрөнгийн төлөлт ба зарцуулалтын байдлыг шалгаж 146,7 мянган төгрөгийн зөрчил дутагдал илрүүлж шалгалтын мөрөөр арга хэмжээ авсан юм.

Гэсэн ч нийгмийн даатгалын үйлчилгээг сайжруулж түүнд олон нийтийн хяналт нэвтрүүлэх талаар манай ажилд үлэмжхэн дутагдал оршиж байна.

МҮЭ—ийн IX их хурлын шийдвэрт улсын нийгмийн даатгалаар даатгагдсан хөдөлмөрчдөд үйлчлэх үйлчилгээг улам боловсронгуй болгож өргөтгөн сайжруулахыг онцлон заасан юм.

Энэ заалтыг биелүүлэхэд нийгмийн даатгалын бүх идэвхтэн байгууллага, ҮЭ—ийн Зөвлөл, хороо, үйлдвэр аж ахуйн газрын захиргаад, эмнэлгийн байгууллагуудаас тавих хяналт, анхаарлыг улам бүр идэвхжүүлж эдгээр байгууллагын хамтын чармайлтыг сайжруулах явдал хамгийн чухал юм.

ҮЭ—ийн Зөвлөл, хороо, бүлэг, тэдгээрийн дэргэдэх нийгмийн даатгалын зөвлөл, төлөөлөгч зэрэг идэвхтэн байгууллагуудаас БНМАУ—ын тэтгэвэрийн хууль, улсын нийгмийн даатгалын хөрөнгөөс тэтгэмж олгох тухай дүрэм, эмнэлгийн хуудас бичиж олгох журмын тухай заавар, бусад холбогдох хууль тогтоомжийг өөрсдийн түшиглэсэн байгууллагуудад хэрхэн биелж байгаад үргэлж хяналт тавьж байх хэрэгтэй.

Улсын нийгмийн даатгалаар даатгагдагчдад үйлчлэх үйлчилгээнд захиргааны талаас байнга анхаарал тавьж ажилчин албан хаагчдын эрүүл мэндийг сайжруулах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөр ахуйн нөхцлийг дээшлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах ёстой.

Нийгмийн даатгалын арга хэмжээний тухай үйлдвэрлэлийн байнгын зөвлөлгөөн, ажилчин албан хаагчдын хурал зөвлөлгөөнөөр хэлэлцүүлж тэдний санал шүүмжлэлийн мөрөөр ажлаа зохиодог байвал зохино.

Улсын нийгмийн даатгалын энэ ажилд ҮЭ—ийн хороо,бүлэг, түүний идэвхтнүүд, албан үйлдвэр эмнэлгийн газрууд сайн туслаж, хяналт тавьж ажилласнаар ажилчин албан хаагчдад нийгмийн даатгалаар үйлчлэх ажлыг сайжруулж чадна.

**Аймгийн ҮЭ--ийн Зөвлөлийн дарга**

**Д. Лувсандорж**

Олон түмнийг үзэл суртлын талаар хүмүүжүүлэх чухал хэрэглүүрийн нэг болсон сонин хэвлэл нь нийгмийн амьдралын хөгжилтөд асар их нөлөө үзүүлдэг.

Монгол ардын нам төрийг үндэслэн байгуулагч Д. Сүхбаатар коментерний тусламжтайгаар үүсгэн бий болгосон Монголын хэвлэл нь ЗХУ-ын хэвлэлийн адил шинэ маягийн хэвлэл бөгөөд Марксист—ленинист үзэл санааг гуйвалтгүй баримталж хамтын ухуулагч, сурталч, олон түмнийг зохион байгуулах үүргээ нэр төртэй биелүүлж ирсэн ба хойшид ч биелүүлэх юм.

К.Маркс, Ф.Энгельс, В.И.Ленин нар үнэхээр сэтгүүлч, дарлагдсан ард түмний эрх чөлөөний төлөө тууштай тэмцэгчид байв.

Тийм ч учраас «Сэтгүүлчийн мэргэжил бол тэмцэгчийн мэргэжил» гэж К.Маркс сэтгүүлчийн мэргэжлийг үлэмж өндөр үнэлсэн байдаг.

Хувьсгалын их удирдагчдаас хэвлэлийн ажилтан нарт өөрийнхөө үйл ажиллагааг намын ажил, намын практиктай холбон ажиллахыг сургаж байсан ба В.И.Ленин гайхамшигтай хэвлэн нийтлэгч байсан бөгөөд сэтгүүлчийн мэргэжил болон хэвлэн нийтлэх ажлыг үлэмж хүндлэн үздэг байсан юм.

В.И.Ленин өөрийгөө сэтгүүлч, нийтлэгч гэж нэрлэдэг байсан ба бүр 1920 онд Зөвлөлт төрийн тэргүүн байх үедээ орсын коммунист(большевикуудын)намын Москвагийн байгууллагын гишүүдийг бүртгэх анкетын ямар мэргэжилтэй вэ? гэдэг асуултанд «нийтлэгч», «сэтгүүлч» гэж хариулан бичиж байсан бөгөөд 1921 онд Москвагийн зөвлөлийн гишүүний хувийн хэргийн асуултанд мөн дээрхийн ижил хариу бичжээ.

В.И.Лениний редакторын болон сэтгүүлч, намын хэвлэлийн ажилтны өндөр үүрэг хариуцлагыг хэрхэн ухамсарладаг, зарчимч шаардлагатай сонины ажилтан нарын хүчийг зөв нэгтгэж тэдэнд тусладаг, уншигчдын санал хүсэлтийг анхааралтай сонсож хамт олны санал бодол дээр тулгуурлан сонины өдөр бүрийн аар саар ажиллагаанд ч гэсэн үлэмж анхаарал тавьж ажилладаг зэрэг гайхамшигт үйл ажиллагаа нь түүний хэвлэлийн талаар үлдээсэн баялаг өвийн чухал хэсэг нь юм.

# Бичлэгийн уран чадвар

Сонин бүхэн өөрийн идэвхтэн бичигч, ажилчин малчны сурвалжлагчтай байдаг бөгөөд тэдний дотроос манай туршлагатай мэргэжил мэдлэгтэй сэтгүүлчид байнга төрөн гарч байдаг билээ.

Манай залуу үеийнхний сонгож авдаг сонирхолтой мэргэжлийн нэг бол сэтгүүлчийн мэргэжил болж байна.

Идэвхтэн бичигч ажилчин малчны сурвалжлагч гэдэг нэр хүндтэй ажил нь өндөр итгэл найдварын хэрэг байдаг юм.

Сонины газар нь өөрийн орон тооны таван ажилчидтай байхаасаа гадна таван зуун идэвхтэн бичигч, ажилчин тариачны хэдэн зуун сурвалжлагчтай байх хэрэгтэй гэж В.И. Ленин сургасан юм.

Ажилчин малчны сурвалжлагч идэвхтэн бичигчээр чухам ямар хүн байвал зохихыг аваад үзье.

Тийм хүн юуны өмнө хувийн талаар үлгэр жишээч, үнэнч шудрага, санаачлагч байвал зохино.

Гэхдээ заавал МХЗЭ-ийн гишүүн, тэргүүний сайн малчин ажилчин хүн байна гэх явдалгүй заавал сайн бичиг үсэгтэн байхыг ч шаардахгүй.

Хамгийн чухал нь үнэн зөв эрүүл санаа сэтгэлтэй байх нь чухал.

Идэвхтэн бичигч ажилчин малчны сурвалжлагч хүн биеэ цаг ямагт боловсруулж эрдэм сурлагын төлөө уйгагүй оролдогч байхаас гадна төрөлх хэлээ сайн мэддэг, яруу сайхан хэллэг, хурц тодорхой дүрслэлээр эвтэй аятайхан, зохион бичигч цаг хугацаа алдалгүй хэвлэн нийтлэгч байхын төлөө, тэмцэгч баймааж зорилгоо сая хангаж чадна.

Ингэхэд идэвхтэн бичигч ажилчин малчны сурвалжлагч хүмүүсийн өдөр дутмын сайн туслагч хамгийн ойрхоны багш бол сонин хэвлэл юм.

Ахмад сэтгүүлч, нэрд гарсан хэвлэн нийтлэгчийн бичсэн найруулснаас цаг ямагт суралцах замаар манай залуу үеийнхний дундаас туршлагатай сайн идэвхтэн бичигч сэтгүүлчдийг төрүүлэн гаргаж чадна.

Шинжлэх ухааны коммунизмын үндсийг тавигч К.Маркс пролетарийн шинэ маягийн намыг үндэслэн байгуулагч түүнийг жолоодогч В.И.Ленин, манай их удирдагч,аймшиггүй чин зоригт Д.Сүхбаатар нарын үйл амьдрал ямагт хэвлэлтэй холбоотой байсан байна.

Сэтгүүлч хүн нийгмийн тодорхой нэг ангийн эрх ашгийг хамгаалсан онол улс төрийн бэлтгэл мэдлэгтэй, утга зохиолын сайн арга барилтай байх ёстой.

Сэтгүүлч, идэвхтэн бичигч хүн зөвхөн уншихад эвтэй аятай урлагтайхан бичсэнээрээ биш харин бодит байдлын дунд орж баримт, учир шалтгааныг тодорхой мэдэж тэр зүйлд намч зарчимч зөв дүгнэлт хийж олон түмнийг цаашид юу хийх тухай зохион байгуулснаараа бичлэгийнхээ уран чадвараа харуулах бөгөөд амьдралыг гүн гүнзгий судлах хэрэгтэй.

Хэвлэлийн үг үхэшгүй мөнх түүний нөлөөлөх хүчин чадал хязгаарлашгүй их юм.

Үүнээс үндэслэн идэвхтэн бичигчид өөрийнхөө бичлэгийн ур чадварт өргөн мэдлэгтэй, өндөр шаардлагатай хандах ёстой.

Сэтгүүлч,идэвхтэн бичигч хүнд хойш тавих ажил гэж байж болохгүй.

Бүх юмыг тэр даруйд нь өдөрт нь багтааж мэдээлэх сурвалжлах үүрэгтэй. Ингэхлээр сэтгүүлч, идэвхтэн бичигч хүн сурвалжлах ажлаа урьдаас сайн боловсруулсан төлөвлөгөөтэй асуудлыг зөвөөр сонгон авсан байх явдал чухал байдаг.

Яарч тулгамдаад хүний амаар дам дамаа сураглан хагас дутуу ажиллаад бичсэн мэдээ нь ямарч буруу зүйлд хүргэж болохыг нэн анхаарууштай юм.

Ер нь сурвалжлах зүйлийг орон нутгийн нам, олон нийтийн байгууллагын үнэлэлт дүгнэлттэй холбон үзэх хэрэгтэй байдаг.

Манай эхлэн бичигчид, идэвхтэн сурвалжлагчид хэн боловч аливаа асуудлыг сурвалжлахдаа уг зүйлийн нийтлэг талаас нь авч үзэх хэрэгтэй.

Хэмжээгээр том, болсон явдал нь нэртэй цуутай хир нь нийтлэг талаас нь ажсан хүнд шальтай биш бол түүний тухай цаас бэх гарздаж суусаны хэрэг юу байхав.

Болсон явдал нь төдий л цуурайтай биш ажиглагдамгүй үл ялихан зүйл мэт атлаа сайн ажсан хүнд их ирээдүйтэй, нийгэмд үлэмж ашигтай зүйл байж болох юм, тэгвэл сурвалжлагч хүн ийм юмны дэргэдүүр эс анхаарсан юм шиг өнгөрч тун болохгүй.

Энэ бол сэтгүүлч хүний гярхай авхаалжтай байхыг шаардана.

Сонин хэвлэлийн ажилтан,идэвхтэн бичигчид нар бол манай намын үзэл суртлын хамгийн идэвхтэй зүтгэлтэн мөн.

Хэвлэлийн ажилтан, сэтгүүлч, идэвхтэн бичигчид нам, засгийнхаа өмнө энэ хүндтэй үүргийг нэр төртэй биелүүлэх нь эргэлзээгүй бөгөөд ингэснээрээ манай оронд социализмын бүрэн ялалтыг хангахад өөрийнхөө хувь нэмрийг оруулж байгаа хэрэг юмаа.

Н.Мөнхөө



ЗУРАГ ДЭЭР: Сэргэлэн сумын «Авдархангай» нэгдлийн 1 дүгээр бригадын хэвлэл тараагч Хорлоо хэвлэл хүргэхийн өмнө.

Гэрэл зургийг Л. Дамдиндорж



Аймгийн төвийн 10 жилийн Дөрвөнжин ахлагчтай сурагчдын сурвалжлах хэсэг 1967 онд 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан цагаасаа хойш Жаргалантын 10 жил, Батсүмбэрийн 8 жил зэрэг төв хөдөөгийн албан байгууллагуудын дэргэдэх сурвалжлах хэсэгтэй холбоо тогтоож 100 гаруй найруулал, сурвалжлага мэдээ материалыг сонин хэвлэлд бичсэний дотор 1968 онд 20 гаруй мэдээ бичээд байна.

ЗУРАГ ДЭЭР: Төвийн 10 жилийн Дөрвөнжин ахлагчтай сурвалжлах хэсэг сонинд нийтлэгдсэн мэдээгээ уншин ярилцаж байна.

## *Хэвлэлийн түүхийн хуудас сөхөхөд*

Монголын хэвлэл үүсч хөгжсөн түүхийг судлах нь эрдэм шинжил гээний үүднээс ач тустайгаар барахгүй өнгөрөгч үеийн өв соёлыг ангилж аль дэвшилттэйг нь авч эзэмшихэд тус дөхөм үзүүлнэ.

Монгол хэл дээр гарч байсан анхны сонин сэтгүүлийн нэг нь «монгол үгийн бодрол» анх 1908 оны 5 дугаар сараас 1909 оны 5 дугаар сард Хятадын Гирин мужийн захиргаанаас «Бүгдийг захирагч сайд, амбан нарын тушаалаар», «Монгол үгийн бодрол» хэмээх сонинг сард нэг удаа «бүх Монголд»үзүүлэх зорилгоор нийтлэн гаргаж байв.

Үүний дараа дараачаар Монгол ер үгийн сэтгүүл (1911 оны 8 дугаар сар—1914 оны 9 дүгээр сар), Шофаны өдрийн сэтгүүл (1919 оны 6 дугаар сар—11 дүгээр сарын 1), Монголын сонин бичиг (1909 оны 5 дугаар сар—1918 оны 12 дугаар сар) зэрэг сонин сэтгүүлүүд гарч байсан бөгөөд үүний дараачаар Монголын дэвшилт ардчилсан сонин сэтгүүлүүд гарах болов.

М.Наморай

ЭНЭ НҮҮРИЙГ МАНАЙ ОЛОН ЗУУН ИДЭВХТЭН БИЧИГЧДЭД ЗОРИУЛАВ.